



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/300

Арвайхээр сум

**Өрхийн мэдээллийн сангийн судалгааг
зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг зохион байгуулах тухай” А/88 дугаар тушаал, Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А/16-А/04 дүгээр хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.“Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал”-аар нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн мэдээллийг шинэчлэх, мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд нэгдсэн чиглэл, зөвлөмж, зөвлөн туслах, хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Судалгааны ажлыг нэгдсэн удирдамжийн дагуу зохион байгуулж, судалгааны дүн мэдээллийг 2023 оны 06 дугаар сарын 05-ны дотор танилцуулахыг аймгийн Засаг даргын орлогч, ажлын хэсгийн ахлагч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




А.ИШДОРЖ

6223 11 0568

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар
сарын 10-ны өдрийн 130 дугаар
захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын даргын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

О.Түмэнжаргал (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Статистикийн хэлтсийн дарга)

Б.Цэдмаа (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)

Г.Чимэддагва (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Цагдаагийн газрын дарга)

Д.Одонбаяр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын дарга)

Д.Амартүвшин (аймгийн Авто тээврийн төвийн дарга)

Нарийн бичгийн дарга: М.Нямсүрэн (аймгийн Засаг даргын эрхлэг асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

-оОо-